

ТАНИЛЦУУЛГА

“Төв аймгийн Алтанбулаг, Аргалант, Эрдэнэ, Сэргэлэн, Баяндэлгэр, Баян, Баянчандмань сумдын хилийн цэсийг шинэчлэн тогтоох тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийн талаар

Бүгд Найрамдах Монгол Ард Улсын Ардын Их хурлын тэргүүлэгчдийн 1982 оны 131 дүгээр зарлигийн нэгдүгээр хавсралтаар Нийслэлийн хилийн цэсийг, хоёрдугаар хавсралтаар Төв аймгийн Батсүмбэр, Архуст, Эрдэнэ, Баянжаргалан сумдын хилийн цэсийг тогтоосон.

Улсын Их Хурлын 1996 оны 24 дүгээр тогтоолоор Нийслэлийн хилийн цэсийг тэлж шинэчлэн баталсан бөгөөд энэхүү тогтоолын 2 дугаар заалтаар “Нийслэлийн хилийн цэсийг баталсантай холбогдуулан Төв аймгийн Алтанбулаг, Аргалант, Эрдэнэ, Сэргэлэн, Баяндэлгэр, Баян, Баянчандмань сумдын хилийн цэсийг шинэчлэн боловсруулж Монгол Улсын Их Хуралд өргөн мэдүүлэхийг Засгийн газарт даалгасугай” гэж заасныг Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль шинэчлэгдэн батлагдах хүртэл хэрэгжих боломжгүй байсан тул дээрх сумдын тодорхой хэсгүүдэд газар нутгийн давхцал үүссэн байдаг.

Мөн тогтоолын 3 дугаар заалтад “Энэ тогтоол гарсантай холбогдуулан Ардын Их Хурлын тэргүүлэгчдийн 1982 оны 131 дүгээр зарлигийг хүчингүй болгонд тооцсугай” гэж заасанаар Төв аймгийн Батсүмбэр, Архуст, Эрдэнэ, Баянжаргалан сумдын хилийн цэс бүхэлдээ хүчингүй болж нийслэлтэй хил залгаа биш Төв аймгийн Архуст, Баянжаргалан сумдын хилийн цэс хүчингүй болсон.

Үүнийг Улсын Их Хурлын 1998 оны 42 дугаар тогтоолоор “Улсын Их Хурлын 1996 оны 24 дүгээр тогтоолын 3 дахь заалтын “131 дүгээр зарлигийг” гэснийг “131 дүгээр зарлигийн 1 дүгээр хавсралтыг” болгон өөрчилсүгэй” гэж зохицуулсан хэдий ч Ардын Их Хурлын тэргүүлэгчдийн 1982 оны 131 дүгээр зарлигийн хоёрдугаар хавсралт болон хоёрдугаар заалт буцан сэргэж нийслэл болон Төв аймгийн хилийн цэсийн маргаан, газар нутгийн давхцал үүссэн. Тухайлбал, Төв аймгийн Эрдэнэ сумын хилийн цэс 1982 оны 131 оны зарлигаар хэвээр үлдэж, Нийслэлийн 1996 оны 24 дүгээр тогтоолоор батлагдсан Налайх дүүргийн хилийн цэсийг тогтоосон нь тухайн засаг захиргааны нэгж хооронд газар нутгийн давхцал, хилийн цэсийн маргаан үүссэн.

“Газрын шинэтгэлийн үндэсний хороо”-ны 2020 оны 08 дугаар хуралдаанаас “Нийслэлийн Налайх дүүрэг, Төв аймгийн Эрдэнэ сум хоорондын хилийн цэсийн асуудлыг 1996 оны Улсын Их Хурлын 24 дүгээр тогтоолын хоёрдугаар заалтын дагуу Нийслэлийн хил залгаа сумдын хилийн цэсийг шинэчлэн Улсын Их Хуралд өргөн барихыг Барилга, хот байгуулалтын яам, Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн газарт тус тус даалгасан.

Энэ хүрээнд Барилга, хот байгуулалтын яам, Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн газраас Засгийн газрын 2003 оны 28 дугаар тогтоолоор батлагдсан “Газар зохион байгуулалт хийх журам”-ын дагуу Нийслэл болон Төв аймгаас хилийн цэсэд өөрчлөлт оруулахтай холбогдсон үйл ажиллагааг үе шаттайгаар зохион байгуулснаар холбогдох Нийслэл, Төв аймгийн н иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын тогтоол, зохих саналыг ирүүлсэн.

Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас 2021 оны 12 дугаар сарын 10-ны өдрийн 169 дүгээр тогтоолоор Монгол Улсын Их Хурлын 1996 оны 24 дүгээр тогтоолыг хэвээр үлдээх санал, Төв аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн Хурлаас 2021 оны 03 дугаар тогтоолоор Эрдэнэ сум, 04 дүгээр тогтоолоор Сэргэлэн сум, 05 дугаар тогтоолоор Баянчандмань сум, 06 дугаар тогтоолоор Алтанбулаг сум, 07 дугаар тогтоолоор Аргалант сум хилийн цэсийг УИХ-ын 1996 оны 24 дүгээр тогтоолоор батлагдсан дүүргүүдийн хилд тодорхой хэмжээний өөрчлөлт оруулж батлуулах саналыг тус тус ирүүлсэн.

Холбогдох хууль тогтоомж, журмын дагуу ирүүлсэн дээрх санал, тогтоол, шийдвэрт үндэслэн зохих тооцоо, судалгааг хийж, орон нутгийн удирдлага, иргэд олон нийтээр асуудлыг удаа дараа хэлэлцүүлэх ажлыг зохион байгуулан ажилласан.

Давхцал үүссэн хилийн цэсийн бүс нутагт Төв аймгийн Алтанбулаг сумын Засаг даргын шийдвэрээр олгосон 21, Аргалант сумын Засаг даргын шийдвэрээр олгосон 3, Баянчандмань сумын Засаг даргын шийдвэрээр олгосон 211, Эрдэнэ сумын Засаг даргын шийдвэрээр олгосон 1622, Сэргэлэн сумын Засаг даргын шийдвэрээр олгосон 212 нийт 2069 иргэн, хуулийн этгээдийн газар эзэмших, ашиглах, өмчлөх асуудалд хүндрэл гарч байна.

Төв аймгийн Алтанбулаг сумын нутаг дэвсгэрээс 2711 га газрыг Хан-Уул дүүрэгт, Баяндэлгэр сумын нутаг дэвсгэрээс 39576 га газрыг Багануур дүүрэгт, Баян сумын нутаг дэвсгэрээс 15497 га газрыг Багахангай дүүрэгт, Эрдэнэ сумын нутаг дэвсгэрээс 54000 га, Сэргэлэн сумаас 9743 га газрыг Налайх дүүрэгт, Баянчандмань сумын нутаг дэвсгэрээс 3383 га, Аргалант сумаас 7471 га газрыг Сонгинохайрхан дүүрэгт хамааруулан талбайн хэмжээг нэмэгдүүлж, харин Сонгинохайрхан дүүргийн нутаг дэвсгэрээс Баянчандмань сумд 4635 га газраар нэмэгдүүлж хилийн цэсийг өөрчилсөн байх тул тогтоолын хэрэгжилтийг хангаж дээрх сумдын хилийн цэсийг шинэчлэн шийдвэрлэх зайлшгүй шаардлагатай юм.

Монгол Улсын Үндсэн хуулийн тавин наймдугаар зүйлийн 2 дахь хэсэгт “Аймаг, нийслэл, сум, дүүргийн хилийн цэсийг Засгийн газрын өргөн мэдүүлснээр Улсын Их Хурал батална”, Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт “Аймаг, сум, нийслэл, дүүргийн хилийн цэсийг Засгийн газрын өргөн мэдүүлснээр Улсын Их Хурал батална”, Газрын шинэтгэлийн үндэсний хорооны хуралдааны 2020 оны 08 дугаар тэмдэглэлээр өгсөн үүрэг даалгаврыг үндэслэн Монгол Улсын Их Хурлын 1996 оны 24 дүгээр тогтоолын 2 дугаар заалтаар “Нийслэлийн хилийн цэсийг баталсантай холбогдуулан Төв аймгийн хил залгаа Алтанбулаг, Аргалант, Эрдэнэ, Сэргэлэн, Баяндэлгэр, Баян, Баянчандмань сумдын хилийн цэсийг шинэчлэн боловсруулж Улсын Их Хуралд өргөн мэдүүлэхийг Засгийн газарт даалгасугай” гэж заасны дагуу дээрх сумдын хилийн цэсийг шинэчлэн боловсруулсан болно.

Дээрх хууль эрх зүйн үндэслэл, практик шаардлагын дагуу “Төв аймгийн Алтанбулаг, Аргалант, Эрдэнэ, Сэргэлэн, Баяндэлгэр, Баян, Баянчандмань сумдын хилийн цэсэд өөрчлөлт оруулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг боловсруулсан болно.